

## МОНГОЛ УЛС БОЛОН ДЭЛХИЙ НИЙТИЙН 2015 ОНООС ХОЙШХИ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

*Хамтран зохион байгуулагч:  
Эдийн засгийн хөгжлийн яам*

*2012 оны 12-р сарын 5, 9:45-12:00  
Чингис Хаан Зочид буудал, Улаанбаатар хот*

### ТОЙМ

Мянганы хөгжлийн зорилтын (МХЗ) хэрэгжилтийг дүгнэх 2015 он ойртох тусам түүнээс цаашхи хөгжлийн зорилтын асуудлаар олон төрлийн хэлэлцүүлэг дэлхий дахинаа өрнөж байна. Эдгээр хэлэлцүүлгийг удирдан чиглүүлэх, зөвлөмж гаргах асуудлыг хариуцсан дээд хэмжээний Ажлын Хэсгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар байгуулсан билээ.

Олон салбарыг хамруулан өргөн хүрээтэй явагдах ийм хэлэлцүүлгүүд нь хүн төрөлхтний хүсэл эрмэлзлэл, дуу хоолойг тусгасан хөгжлийн зорилтуудыг гаргахад маш чухал үүрэг гүйцэтгэх төдийгүй улс орнууд цаашид тэдгээр зорилтыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхэд тус болох юм.

2015 оноос хойш тавигдах хөгжлийн зорилтын асуудлаарх энэхүү хэлэлцүүлгийг дэлхийн улс орнууд дор бүрдээ дараах зорилготойгоор зохион явуулж байна.

- Дэлхий нийтээрээ нэг зорилготойгоор эх дэлхийнхээ цаашдын хөгжлийн зорилтууд ямар байх талаар харилцан зөвшилцөж тодорхой зөвлөмж гаргах;
- Ядуу болон эмзэг хэсгийнхний дуу хоолойг сонсох, ил тод болгох;
- Өргөн олны хүсэл сонирхлыг тусгасан Засгийн газар хоорондын харилцан уялдаатай, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

Монгол Улсад зохиогдохоор төлөвлөгдөж буй 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтын талаарх бусад хэлэлцүүлэгт иргэний нийгэм, хувийн хэвшил, сургалт судалгааны байгууллагууд болон залуучуудын төлөөллийг хамруулах бөгөөд дуу хоолой нь тэр бүр хүрдэггүй нийгмийн хэсгийн оролцоог хангахад онцгойлон анхаарч байна.

Энэ удаагийн “Монгол Улс болон дэлхий нийтийн 2015 оноос хойшхи хөгжлийн зорилт” сэдэвт өндөр түвшний хэлэлцүүлэг нь дэлхий даяар өрнөж буй үйл

явцад хувь нэмэр оруулахаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, Монгол Улсын Засгийн газрын хамтран зохион байгуулахаар төлөвлөж байгаа дээрх хэлэлцүүлэгтэй цаг хугацааны хувьд давхцаж байна.

Тус хэлэлцүүлэг нь Монгол Улсын цаашдын хөгжилд шууд ач холбогдол бүхий асуудлыг онцолж, тэдгээр асуудал нь Мянганы хөгжлийн зорилтуудыг дүгнэх 2015 оноос хойш дэлхий нийтийн өмнө тавигдах хөгжлийн зорилтуудтай хэрхэн уялдах талаар ярилцах зорилготой.

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Хэлэлцэх сэдвийн хүрээнд олон чухал асуудлыг ярилцах бөгөөд заримаас нь дурдвал:

- **2015 оноос хойшхи хүн төрөлхтний хөгжлийн зорилтын талаар хэлэлцэх зарчим** - Дэлхийн улс орнууд хүн төрөлхтний өмнө нийтлэг тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлэхийг чармайх ёстой юу, эсвэл улс орнууд тус бүрдээ өөр өөрийн хөгжлийн зорилтуудыг тавих ёстой юу. Түүнчлэн 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудад хүний эрхэнд тулгуурласан зарчмыг хир хэмжээнд баримтлах, улс орнуудын Засгийн газрууд иргэддээ нийгэм, эдийн засаг, улс төрийн эрхийг олгох асуудлыг хэрхэн гол зорилгоо болгох, тэднийхээ өмнө засгийн газруудын хүлээх хариуцлагыг аль хир өндөрт гаргаж тавих вэ гэх зэрэг сэдэв байж болно.
- **Монгол Улсын хувьд 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудад тусгагдвал зохих гол асуудлууд** - Үүнд ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах, тогтвортой хөгжил, хүний хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, болзошгүй аюул эрсдэлд бэлтгэлтэй байх нөхцөлийг өргөжүүлэх, нийгмийн хамгааллыг бэхжүүлэх замаар ядуус, эмзэг хэсгийнхний эмзэг байдлыг бууруулах зэрэг асуудлыг ярилцаж болох юм.

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү хэлэлцүүлэгт “**2015 оноос хойшхи хөгжлийн чиглэлд тогтвортой хөгжлийн зорилтыг тусгах нь**” сэдвээр Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, “**2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудад тусгагдах шаардлагатай Монгол Улсын нэн тулгамдсан асуудлууд**” сэдвээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас тус тус илтгэл тавина. Дараа нь нээлттэй хэлэлцүүлэг явагдана.